



ОЙ МОДНЫ СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ОРНЫ ОЙ

2024 ОНЫ 1 ДЭХ ДУГААР



ОЛОН УЛСЫН ОЙН ӨДӨР

ОЙ БА ИННОВАЦ

ИЛҮҮ САЙХАН ДЭЛХИЙ ТӨЛӨӨХ ШИНЭЛЭГ ШИЙДЛҮҮД

АГУУЛГА

3

ОЛОН УЛСЫН ОЙН ӨДРИЙН
МЭНДЧИЛГЭЭ

5

НҮБ-ИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙГУУЛЛАГААС ОЛОН УЛСЫН ОЙН
ӨДӨРТ ЗОРИУЛСАН УРИАЛГА

6

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
САНААЧИЛГААР ЗОХИОН
БАЙГУУЛСАН "ОЙ 9+" ОЙН
САЛБАРЫН ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР
ЧУУЛГАНЫ ТАЛААР

10

ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ

12

ХӨВСГӨЛИЙН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ОНЦЛОХ АЖЛУУДААС

16

ЭРДЭНЭТ ОЙН ГЕНЕТИКИЙН ТӨВИЙН
ТЭРБУМ МОД УРГУУЛАХАД ОРУУЛЖ
БУЙ ХУВЬ НЭМЭР

22

ТЭРБУМ МОД САНГИЙН
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА СУДАЛГААНЫ
АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС

30

ХУШ МОДНЫ БОРГОЦОЙ, САМАР
БЭЛТГЭХ ТӨХӨӨРӨМЖИЙН
СУДЛАГДСАН БАЙДАЛ

36

БИОМАССЫГ ХӨРВҮҮЛЭХ
ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ
ТАНИЛЦУУЛГА

42

ОЙ МОД БА МӨӨГ

45

ДОРойТОЛД ОРСОН ОЙН МОДЫГ
АШИГЛАН ЦЭЦЭРЛЭГИЙН
ХҮҮХДИЙН МОДОН ТОГЛООМ ХИЙХ
БОЛОМЖИЙН СУДАЛГАА

60

УЛААНБААТАР ХОТЫН НОГООН
БАЙГУУЛАМЖИЙН ТАРИМАЛ
МОДДЫН ҮРИЙН ЧАНАР, ТАРЬЦЫН
ӨСӨЛТ

70

МОНГОЛ ОРНЫ ОЙТ ХЭЭРИЙН БҮСИЙН БАЙГАЛИЙН
ШИЛМҮҮСТ ОЙН ШИГҮҮРЭЛ, СЭРГЭН УРГАХ ЧАДВАРТ
НӨЛӨӨЛӨХ НЬ (НАРСАН ОЙН ЖИШЭЭН ДЭЭР)

81

"ХУШИН ОЙГОО ХАМГААЛЪЯ"
ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ
МАНЛАЙЛАГЧДЫН БҮТЭЭЛЭЭС

УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТАРИМАЛ МОДДЫН ҮРИЙН ЧАНАР, ТАРЬЦЫН ӨСӨЛТ

57

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ, ТЕХНОЛОГИ

¹Ойн генетик, экофизиологийн лаборатори, МУИС

²Газарзүй, геоэкологийн хүрээлэн, ШУА

³"Ногоон хөгжил" төслийн нэгж, Эрдэнэт үйлдвэр, ТӨҮГ

*Холбоо баригч зохиогч: nbatkhuu@gmail.com

ХУРААНГУЙ:

Энэхүү судалгаа нь нийслэл Улаанбаатар хотын ногоон байгууламжид тарималжуулсан Шар хуайс, Далан хальс, Голт борын үрийн чанар (1000 үрийн жин, ургах эрчим, соёлолт, үрийн амьдрах чадвар), тарьцын өсөлт, биомассын хуваарилалт, хуримтлал, тарьцын чанарыг тодорхойлов. Үр болон тарьцын судалгааг Монгол улсад мөрдөгддөг стандартууд [1; 2], Олон улсын үрийн чанарын шинжилгээний журам [3], тарьцын чанарыг [4; 5; 6] баримтлан ажиллав. Шар хуайсын үрийн соёлолт (20 хоногт) 81% буюу соёлолтын эцсийн тооллогоор I-р зэргийн үр, Далан хальсны үрийн соёлолт (30 хоногт) 61% байгаа нь стандартын дагуу II-р зэргийн үр, Голт борын үрийн соёлолт (30 хоногт) 50% буюу III-р зэргийн үртэй байна. Монгол улсад мөрдөгдөж буй тарьцын чанар тодорхойлох стандартын дагуу (хамгаалагдсан орчинд 1–2 настай тарьцын зэрэг) туршилтад ашигласан Далан хальс, Голт борын үр II–III зэргийн үртэй байгааг илтгэж байгаа боловч тарьцын чанар (DQI) тодорхойлох аргачлалаар Голт бор, Далан хальс сайн чанарын тарьц ургаж байгааг илтгэж байна. Шар хуайсын тарьц II-р зэрэгт хамаарагдаж байгаа боловч тарьцын чанарын (DQI) зэргээр доогуур үзүүлэлттэй байна. Үүнээс харахад үрийн чанарын зэргийг үр ургуулах, соёлуулах температурын горимыг дахин шинэчлэх замаар нэмэгдүүлэх боломжтой болохыг үр болон тарьцын судалгаа илтгэж байна. Мөн хотын ногоон байгууламжаас үр бэлтгэж тарьц, суулгац бий болгох, тухайн байгууламжид буцаан тарималжуулах боломжтой болохыг илтгэж байна. Моддын үрийн чанарт тухайн жилийн температур, хур тунадас, салхи, мөн орчны бохирдол гэх мэт олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд энэхүү судалгааг мониторинг байдлаар судлах шаардлагатай байна. Мөн үрийн чанар, үрийн зэрэглэл өндөр үрийг тарьж ургуулан, тарьцын өсөлт болон биомасс хуримтлал, экофизиологийн үзүүлэлтүүдийг судлах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Улаанбаатар, ургах эрчим, соёлолт, тарьцын чанар

УДИРТГАЛ

отжилт өргөжин тэлэхийн хэрээр хүрээлэн буй орчныг сайжруулах шаардлага тулгардаг. Дэлхийн ормоохон хот суурин газруудад нэг хүнд ноогдох

ногоон байгууламжийг 16м^2 , дэлхийн жишиг стандартаар 9м^2 байхаар төлөвлөдөг. Нийслэл Улаанбаатар хотын ногоон байгууламжийн талбай